

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 19<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### “19<sup>1</sup> дүгээр зүйл. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ил тод байдал

19<sup>1</sup>.1. Энэ хуульд заасны дагуу хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайланг нэгтгэн хадгалж, олон нийтэд ил тод байдлыг хангахад чиглэсэн үндэсний судалгааны нэгдсэн цахим мэдээллийн сантай байна.

19<sup>1</sup>.2. Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага, зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

19<sup>1</sup>.3. Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана:

19<sup>1</sup>.3.1. энэ хуулийн 3.1.7, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 3.1.11-д заасан эрдэм шинжилгээний ажлын тайлан;

19<sup>1</sup>.3.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тайлан;

19<sup>1</sup>.3.3. тухайн байгууллагын судлаач, эрдэм шинжилгээний ажилтны эрдэм шинжилгээний бүтээлийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн;

19<sup>1</sup>.3.4. хуульд заасан бусад.”

**2 дугаар зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР  
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг:**

“14.9.Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад энэ зүйл хамаарахгүй.”

**2/42 дугаар зүйлийн 42.10 дахь хэсэг:**

“42.10.Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад энэ зүйл хамаарахгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Эцэслэн батлах төсөл  
2026.05.01

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй:

“5/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар академийн харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцох.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг